

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Огноо : 2026 оны 08 дугаар сарын 10

Сонгон шалгаруулалт шалгаруулалтын нэр: **Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт орших MV-013440 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 8-р хүдрийн бүс ордод бүтээгдэхүүн хуваах зарчмаар хамтран ажиллах**

Эрдэнэс критикал минералс ТӨҮГ нь эрх бүхий оролцогчдоос бүтээгдэхүүн хуваах зарчмаар хамтран ажиллах ажлыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн санал ирүүлэхийг урьж байна.

Оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 3 жил буюу 2023, 2024, 2025 онуудад тус бүр 3 тэрбум төгрөгөөс багагүй байх.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:

1 тэрбум төгрөгөөс багагүй байх ба үүнийг: 1. Дансны тодорхойлолт, 2. Уг сонгон шалгаруулалтад ялсан тохиолдолд зээл олгох боломжтой байна гэсэн утга бүхий Захиалагчийн нэр дээр гаргасан банкны тодорхойлолт, 3. Шугаман зээлийн эрх, эдгээрийн аль нэгийг ирүүлсэн бол шаардлага хангасан материал гэж үзнэ.

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **2023, 2024, 2025 оны тайлан ирүүлнэ.**

Ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн байвал зохих хугацаа: **Сүүлийн 3 жил буюу 2023, 2024, 2025 онуудын аль нэг жилд** гүйцэтгэсэн ижил төстэй ажлын үнийн дүн 3 тэрбум төгрөгөөс багагүй байх. Ижил төстэй ажил гэдэгт уул уурхайн ашиглалт, олборлолтын чиглэлээр ажиллаж байсан гэж ойлгох бөгөөд тухайн ажлыг гүйцэтгэж байсан туршлага, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон гэрээ, гэрээ дүгнэсэн акт эсхүл өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт шаардлагатай.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Үгүй**

Саналыг 2026 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй аж ахуйн нэгжийн эрх бүхий эсхүл итгэмжлэгдсэн оролцогчдыг байлцуулан сонгон шалгаруулалтыг 2026 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 10 цаг 10 минутад нээнэ.

Гадаадын хуулийн этгээд санал ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: Эрхгүй

Сонгон шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлт хүлээн авах болон баримт бичгийг оролцогчид олгох хугацаа нь саналыг нээхээс хуанлийн 5 хоногоос багагүй байна.

Сонгон шалгаруулалтын баримт бичгийг авахдаа сонирхогч этгээд нь албан тоотоор хүсэлт гаргах ба урилгад дурдсан mailbox@ecmm.mn цахим хаягаар ирүүлснээр хариу хүргүүлнэ.

Улаанбаатар хот 51, ш/х – 002

Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө. 22-р хороо,
“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ийн байр, 505 тоот өрөө,

И-мейл: mailbox@ecmm.mn.

Утас/факс: 976-11-458380(ф), 976-11-450060-158,